



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ [Эрүүл мэндийн сайдын 2013 оны 03 дугаар тушаалаар хүчингүйд тооцсон](#)

АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ 2011 оны 11 дүгээр сарын 09- ний өдөр Улаанбаатар хот Дугаар 366 Эрүүл мэндийн тухай хуулийн 41.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ: 1."Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журам"-ыг нэгдүгээр, "Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх бодисын улсын бүртгэлийн гэрчилгээний загвар"-ыг хоёрдугаар, "Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх ажил үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын тайлан мэдээний маяг"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай. 2. Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх үйл ажиллагааны стандартыг 2012 оны 2 дугаар улиралд багтаан шинэчлэн боловсруулж, батлуулахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар (Ш.Энхбат), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д үүрэг болгосугай. 3.Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх асуудал хариуцсан лаборатори бүхий тасаг, мэргэжлийн зөвлөл байгуулж ажиллуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д үүрэг болгосугай. 4.Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах халдваргүйжүүлэх үйл ажиллагааны тайлан мэдээг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлж байхыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, ирүүлсэн мэдээг нэгтгэж жил бүрийн 2 дугаар сарын 1-ны дотор Эрүүл мэндийн яамны Халдвар хяналтын зохицуулах зөвлөлд ирүүлж байхыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д даалгасугай. 5.Энэхүү журам батлагдсантай холбоотой Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А-144 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай. 6. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газар /Д.Жаргалсайхан/, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар /Ш.Энхбат/-т үүрэг болгосугай. САЙД С.ЛАМБАА Улсын бүртгэлд 2011 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 3292 дугаарт бүртгэсэн